

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны...дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хот, тосгоны чиг үүрэг, эдийн засгийн үндэс, өөрийн удирдлага, үйл ажиллагааны зарчим, бүрэн эрх, зохион байгуулалт, хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хуулийн зохицуулах харилцаа

2.1.Энэ хуулиар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндэс, тэдгээрийн чиг үүрэг, эдийн засгийн үндэс, хот, тосгоныг байгуулах, татан буулгах нийтлэг журам, хот, тосгоны оршин суугчийн эрх, үүрэг болон хот, тосгоны удирдлага засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарчим чиг үүргийг хэрэгжүүлэх харилцааг зохицуулна.

2.2.Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хот, түүний нутаг дэвсгэр дэх хот, тосгонтой холбогдох үүсэх харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

3 дугаар зүйл.Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль тогтоомж

3.1.Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

3.2.Хот, тосгоны чиг үүрэг, бүрэн эрхийг бусад хуулиар тодорхойлохдоо энэ хуульд заасан зарчим, нийтлэг зохицуулалтыг баримтална.

4 дүгээр зүйл.Хотын эрх зүйн байдал

4.1.Хот нь хуулиар тусгайлан тодорхойлсон чиг үүрэг, өөрийн удирдлага, өөрт олгогдсон эдэлбэр газартай, хот бүрдүүлэгч дэд бүтэц, эдийн засгийн

¹Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

чадавх бүхий, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний дагуу хэрэгжүүлэх нийтийн эрх зүйн этгээд /орон нутгийн корпораци/ мөн.

4.2. Хот нь хууль тогтоомжоор тухайлан зохицуулаагүй эдийн засаг, нийгмийн амьдралынхаа тодорхой асуудлыг Үндсэн хууль, хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.

5 дугаар зүйл. Хотын зэрэглэл

5.1. Улсын эдийн засаг, нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг, үзүүлэх нөлөө, хэрэгжүүлэх өөрийн болон засаг захиргааны чиг үүргийн онцлогийг нь харгалзан хотод улсын болон орон нутгийн зэрэглэл олгоно.

5.2. Улсын зэрэглэлтэй хот 100 001-ээс доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэцтэй, улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд онцгой ач холбогдол бүхий, өөрийн удирдлагатай төвлөрсөн суурин газар мөн.

5.3. Орон нутгийн зэрэглэлтэй хот 20 001-100 000 оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн.

5.4. Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан шаардлагыг хангасан хотод улсын болон орон нутгийн зэрэглэл олгох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

5.5. Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан шаардлагыг бүрэн хангаагүй боловч улсын болон тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг, түүх соёлын ач холбогдол, газар зүйн байршил, бусад онцлогийг харгалзан шаардлагатай гэж үзвэл хотод улсын болон орон нутгийн зэрэглэл олгож болно.

5.6. Хотын оршин суугчдад үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалтын нэгж нь хороо байна.

5.7. Улсын зэрэглэлтэй хотын хороог 15 000-20 000 оршин суугчтайгаар, орон нутгийн зэрэглэлтэй хотын хороог 8 000-аас цөөнгүй оршин суугчтайгаар байгуулах бөгөөд хилийн заагийг хотын Зөвлөл тогтооно.

5.8. Хотын хороог байгуулахад хүн амын байршил, оршин суугчдад үйлчилгээ үзүүлэх дэд бүтэц, бусад онцлогийг харгалзан үзэж шаардлагатай бол энэ хуулийн 5.7-д зааснаас цөөн оршин суугчтай байхаар хотын Зөвлөл тогтоож болно.

6 дугаар зүйл. Тосгоны эрх зүйн байдал

6.1. Тосгон нь 2 000-аас доошгүй байнгын оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг зонхилон хөгжсөн, хотын зарим шинжийг агуулсан, өөрийн удирдлага бүхий суурин газар /орон нутгийн корпораци/ мөн.

6.2.Тосгон нь хууль тогтоомжоор тухайлан зохицуулаагүй эдийн засаг, нийгмийн амьдралынхаа тодорхой асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль, хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.

6.3.Тосгон нь хэсгийн зохион байгуулалттай байж болно.

7 дугаар зүйл.Хот, тосгон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй харилцах зарчим

7.1.Энэ хуулиар тодорхойлсон хот, тосгоны өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага оролцож үл болно.

7.2.Орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгон нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх асуудлаар тухайн нэгжтэй нийтийн эрх зүйн гэрээ байгуулна.

7.3.Хот, тосгон болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь тодорхой асуудлаар хамтарч ажиллаж болно.

8 дугаар зүйл.Хот, тосгон байгуулах, татан буулгах

8.1.Хот, тосгоныг байгуулах, татан буулгах асуудлыг дараах нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

8.1.1.улс болон аймгийн эдийн засаг, нийгмийн амьдралд үзүүлэх нөлөө, ач холбогдол;

8.1.2.хүн амын байршил, нийгмийн үйлчилгээг хүргэх дэд бүтэц;

8.1.3.суурин газрын зам, харилцаа, инженерийн байгууламж, бусад дэд бүтцийн хөгжил;

8.1.4.хүрээлэн буй орчин, оршин буй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үзүүлэх нийгэм, эдийн засгийн нөлөөлөл.

8.2.Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгон байгуулах шийдвэрт тэдгээрийн оноосон нэр, эдэлбэр газрын хэмжээ, газар зүйн нарийвчилсан байршил, тухайн хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийг шилжүүлэх талаар тусгана.

8.3.Хот, тосгоныг байгуулах санаачилгыг хоёр болон хэд хэдэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэд өөрсдийн төлөөллийн байгууллагаар уламжлуулан Засгийн газарт гаргаж болно.

8.4.Хот, тосгоныг нүүлгэн шилжүүлэх, татан буулгахтай холбогдсон харилцааг Хот байгуулалтын тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

9 дүгээр зүйл.Хот, тосгоны эдэлбэр газар

9.1.Хот, тосгон нь эдэлбэр газартай байна.

9.2.Хот, тосгоны эдэлбэр газар нь хэд хэдэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг дамнан байрлах тохиолдолд аль нэг нэгжийн нутаг дэвсгэрт байршуулахаар холбогдох засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэст өөрчлөлт оруулах асуудлыг хууль тогтоомжид заасан журмаар шийдвэрлэнэ.

9.3.Шинээр хот, тосгон байгуулахад эрх бүхий байгууллагын баталсан ерөнхий төлөвлөгөөг үндэслэн эдэлбэр газрыг нь тогтооно.

9.4.Хот, тосгоны эдэлбэр газрыг бусад хот, тосгонд давхардуулан олгож үл болно.

9.5.Хот, тосгонд эдэлбэр газар олгох, түүний хэмжээ, заагийг өөрчлөх асуудлыг хууль тогтоомжийн дагуу Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

9.6.Эдэлбэр газрын төлбөрийг тухайн хот, тосгон оршин байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хууль тогтоомжид заасан журмын дагуу төлнө.

10 дугаар зүйл.Хот, тосгоны удирдлагын зарчим

10.1.Хот, тосгоны өөрийн удирдлага үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна доор дурдсан зарчмыг баримтална:

10.1.1.төрийн байгууламжийн нэгдмэл байдлыг хангах;

10.1.2.оршин суугчийн нийтлэг ашиг сонирхлыг дээдлэх;

10.1.3.асуудлыг шийдвэрлэхэд оршин суугчдын хүсэл зоригийн илэрхийлэл, санал, оролцоог нэн тэргүүнд харгалздаг байх;

10.1.4.үйлчилгээг оршин суугчид тэгш, шударга, нээлттэй хүргэх;

10.1.5.эдийн засгийн шударга өрсөлдөөнийг дэмжих;

10.1.6.эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх;

10.1.7.тогтвортой хөгжлийг хангах;

10.1.8.улс төрөөс ангид байх.

11 дүгээр зүйл.Хот, тосгон эрх зүйн харилцаанд оролцох

11.1.Хот, тосгон нийтийн эрх зүйн этгээд байна.

11.2.Хот, тосгоны Зөвлөл, түүний эрх олгосноор Захирагч нь эрх зүйн харилцаанд хот, тосгоныг төлөөлнө.

12 дугаар зүйл.Хот, тосгоны дүрэм

12.1.Хот, тосгон нь хууль тогтоомжид нийцүүлэн баталсан өөрийн дүрэмтэй байж болно.

12.2. Хот, тосгоны дүрмийг Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу бүртгүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨСӨВ, САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭС

13 дугаар зүйл. Хот, тосгоны төсөв

13.1. Хот, тосгон нь улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан болон өөрийн эх үүсвэрээр бүрдүүлсэн төсөвтэй байна.

13.2. Улсын зэрэглэлтэй хот нь улсын төсөвт, түүний хороо нь тухайн хотын төсөвт тусгайлан тусгасан бие даасан төсөвтэй байна.

13.3. Орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгон нь аймгийн төсөвт тусгайлан тусгагдсан бие даасан төсөвтэй байна.

13.4. Хот, тосгоны төсвийг боловсруулж, батлахдаа оршин суугчдын санал, хүсэлтийг харгалзан үзнэ.

13.5. Хот, тосгоны төсөв нь энэ хуульд заасан хот, тосгоны өөрийн болон түүнд шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

13.6. Хот, тосгон өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нэмж шаардагдах, мөн түүнд шилжүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн болон төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх эх үүсвэрийг холбогдох дээд шатны төсөв, улсын төсвөөс хуваарилна.

13.7. Хот, тосгоны төсвийн харилцааг энэ хуульд заасан зарчмыг баримтлан Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

14 дүгээр зүйл. Хот, тосгоны санхүүгийн эх үүсвэр

14.1. Хот, тосгоны үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр нь хот, тосгоны төсвийн татварын болон татварын бус орлого, улсын болон аймгийн төсвийн санхүүжилтээс бүрдэнэ.

14.2. Хот нь татвартай байх бөгөөд хотын татварыг хуулиар тогтооно.

15 дугаар зүйл. Хот, тосгоны өмч

15.1. Хот, тосгон өмчтэй байна.

15.2. Хот, тосгоны өмчийн удирдлага, өмчлөгчийн эрхийг тухайн хот, тосгоны Зөвлөл, түүний эрх олгосноор хот, тосгоны Захирагч төлөөлөн хэрэгжүүлнэ.

15.3. Хот, тосгоны өмчийн харилцааг хуулиар зохицуулна.

16 дугаар зүйл. Хот, тосгоны сан

16.1. Хот, тосгон нь орон нутгийн хөгжлийн сантай байна.

16.2.Хот нь энэ хуульд заасан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх зориулалт бүхий бусад сантай байж болно.

16.3.Энэ хуулийн 16.2-т заасан санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих журмыг хотын Зөвлөл тогтооно.

16.4.Энэ хуулийн 16-т заасны дагуу тогтоосон журмыг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу бүртгүүлнэ.

17 дугаар зүйл.Хотын чөлөөт бүс

17.1.Хот нь хуулийн дагуу байгуулсан чөлөөт бүстэй байж болно.

17.2.Хотын чөлөөт бүстэй холбоотой харилцааг хуулиар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХОТ, ТОСГОНЫ ЧИГ ҮҮРЭГ БА ХОТ, ТОСГОНД ЧИГ ҮҮРЭГ ШИЛЖҮҮЛЭХ

18 дугаар зүйл.Хот, тосгоны нийтлэг чиг үүрэг

18.1.Хот, тосгон нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.1.хот, тосгоны хөгжлийн бодлого, төлөвлөлт;

18.1.2.хот, тосгоны төсөв, хураамж;

18.1.3. хот, тосгоны өмчийн удирдлага;

18.1.4.хот, тосгоны сангийн төлөвлөлт, хуваарилалт, хяналт;

18.1.5.оршин суугчдын унд, ахуйн хэрэгцээний ус хангамж;

18.1.6.хот, тосгоны авто зогсоолын нийтлэг зохицуулалт;

18.1.7. гудамж, талбайн нэр, хаягжуулалт;

18.1.8.хөшөө дурсгалын байршил, хамгаалалт;

18.1.9.хот тохижилт, явган хүн, тоглоомын талбайн байгууламжийн арчлалт, хамгаалалт;

18.1.10.олон нийтийн амралт, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн ачрлалт, хамгаалалт;

18.1.11.төрийн болон хот, тосгоны өмчийн боловсрол, эрүүл мэнд анхан шатны байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ;

18.1.12.хот, тосгоны өмчийн биеийн тамир, спортын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ;

18.1.13.хог хаягдлын менежмент;

18.1.14.орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ;

18.1.15.гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу;

18.1.16.хот, тосгоны зам, гудамж, талбайн гэрэлтүүлгийн засвар, арчлалт;

18.1.17.хот, тосгоны нутгийн цэвэрлэх байгууламж;

18.1.18.хот, тосгоны доторх зам, гүүр, түүний арчилгаа, тэмдэг тэмдэглэгээ арчлалт, хамгаалалт;

18.1.19.хот, тосгоны чанартай санал асуулга, хэлэлцүүлэгийн зохицуулалт;

18.1.20.оршуулгын газрын зохицуулалт;

18.1.21.хууль тогтоомжид заасан бусад нийтлэг чиг үүрэг.

19 дүгээр зүйл.Хотын чиг үүрэг

19.1.Хот нь энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан чиг үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.1.1.хууль тогтоомжид заасан хотын албан татвар, хураамж;

19.1.2.хотын өмчийн номын сан, соёлын ордны барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ;

19.1.3.хотын нийтийн тээвэр, такси үйлчилгээний зохицуулалт;

19.1.4.хотын аялал жуулчлалын менежмент;

19.1.5.орон сууц, нийтийн аж ахуйн менежмент;

19.1.6.нийтийн ариун цэвэр, цэвэрлэгээ менежмент;

19.1.7.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

20 дугаар зүйл.Улсын зэрэглэлтэй хотын чиг үүрэг

20.1.Улсын зэрэглэлтэй хот энэ хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан чиг үүргээс гадна нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.1.1.хотын дунд хугацааны хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт;

20.1.2.хотын өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт;

20.1.3.хотын төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;

20.1.4.хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох асуудал;

20.1.5.хотын хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;

20.1.6.хотын хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр;

20.1.7.худалдаа, үйлчилгээний нийтлэг зохицуулалт, хяналт;

20.1.8.хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, хэрэгжилтэд тавих хяналт;

20.1.9.хотын хөгжлийн төлөвлөлт, хуваарилалт, тайлан, хяналт, бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;

20.1.10.хотын аялал жуулчлалын бодлого, менежмент;

20.1.11.хот суурин газрын хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, хяналт;

20.1.12. гудамж, талбай, барилга, байшингийн хаягжилтын зохицуулалт;
20.1.13. хөшөө дурсгалын нийтлэг зохицуулалт;

20.1.14. хотын өмчийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, нэгдсэн эмнэлэг, музей, номын сан, театрын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ;

20.1.15. харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт;

20.1.16. хот суурингийн замын хөдөлгөөн, авто зогсоолын нийтлэг зохицуулалт;

20.1.17. аюултай болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежмент;

20.1.18. оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт;

20.1.19. төрийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхээр гэрээгээр тусгайлан шилжүүлсэн асуудал;

20.1.20. хууль тогтоомжид заасан бусад асуудал.

20.2. Улсын зэрэглэлтэй хот, түүний хороо нь энэ хуулийн 20.1-т зааснаас гадна хууль, нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5-д заасны дагуу төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэхээр аймаг, суманд шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

21 дүгээр зүйл. Орон нутгийн зэрэглэлтэй хотын чиг үүрэг

21.1. Орон нутгийн зэрэглэлтэй хот нь эдэлбэр газрынхаа хэмжээнд сумын, хороо нь багийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

21.2. Орон нутгийн зэрэглэлтэй хот нь энэ хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан чиг үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.2.1. хотын удирдлагаар шийдвэрлүүлэхээр аймгийн удирдлагаас гэрээний үндсэн дээр шилжүүлсэн асуудал;

21.2.2. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

21.3. Орон нутгийн зэрэглэлтэй хот нь энэ хуулийн 21.2-т зааснаас гадна хууль, гэрээний үндсэн дээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5-д заасны дагуу төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэхээр суманд шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

22 дугаар зүйл. Тосгоны чиг үүрэг

22.1. Тосгон нь эдэлбэр газрынхаа хэмжээнд сумын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

22.2. Тосгон нь энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан чиг үүргээс гадна дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ:

22.2.1.хуульд заасан болон өөрийн санаачилсан асуудлаар оршин суугчдын нийтлэг санал, хүсэлтийг авах ажлыг зохион байгуулж, зохих шатны байгууллага, албан тушаалтанд уламжлах;

22.2.2.хуульд заасны дагуу тухайн нутаг дэвсгэрийнхээ нийтийн эзэмшлийн газар, зам талбайн газар зохион байгуулалт, орчны эрүүл ахуй, ариун цэврийн байдалд тавих хяналтад иргэдийн оролцоог хангах;

22.2.3.тосгоны удирдлагаар шийдвэрлүүлэхээр сумын удирдлагаас шилжүүлсэн асуудал;

22.2.4.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

22.3.Тосгон нь энэ хуулийн 22.2-т зааснаас гадна хууль, гэрээний үндсэн дээр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дах хэсэгт заасны дагуу төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэхээр суманд шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлж болно.

23 дугаар зүйл.Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх

23.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ дараах шалгуурыг харгалзана:

- 23.1.1.эдийн засгийн бүтэц, чадавх;
- 23.1.2.хүн амын тоо болон газар зүйн байршил;
- 23.1.3.үйлчилгээг хүргэх дэд бүтэц;
- 23.1.4.холбогдох бусад нөхцөл.

23.2.Улсын зэрэглэлтэй хотын эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн аймаг, сумын удирдлагын чиг үүргийг шилжүүлж болно.

23.3.Орон нутгийн зэрэглэлтэй хотын эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн аймаг, сумын удирдлагын чиг үүргийг шилжүүлж болно.

23.4.Тосгоны эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн сум, багийн удирдлагын чиг үүргийг шилжүүлж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХОТ, ТОСГОНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮНДЭС

НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ ХОТ, ТОСГОНЫ ӨӨРИЙН УДИРДЛАГА

24 дүгээр зүйл.Хот, тосгоны Зөвлөл

24.1.Хот, тосгоны өөрийн удирдлагын байгууллага нь оршин суугчдаас сонгосон хот, тосгоны Зөвлөл мөн.

24.2.Улсын зэрэглэлтэй хотын хорооны өөрийн удирдлага нь оршин суугчдаас сонгосон Зөвлөл байна.

24.3.Орон нутгийн зэрэглэлтэй хотын хороо нь хорооны Захирагчид зөвлөх үүрэгтэй Захирагчийн дэргэдэх зөвлөлтэй байна.

24.4.Энэ хуулийн 24.3-т заасан Захирагчийн дэргэдэх зөвлөлийг тухайн хотын нийгэм, эдийн засагт нөлөө бүхий аж ахуйн нэгж, байгууллага болон оршин суугчдын төлөөллийг оролцуулан 5-11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хорооны Захирагч байгуулна.

24.5.Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

25 дугаар зүйл.Улсын зэрэглэлтэй хотын Зөвлөлийн гишүүний тоо

25.1.Улсын зэрэглэлтэй хотын Зөвлөлийн гишүүний тоог доор дурдсанаар тогтооно:

25.1.1.оршин суугчийн тоо нь 100 000 хүртэл бол 31;

25.1.2.оршин суугчийн тоо нь 100 000-ээс дээш бол 35.

26 дугаар зүйл.Улсын зэрэглэлтэй хотын хорооны Зөвлөлийн гишүүний тоо

26.1.Улсын зэрэглэлтэй хотын хорооны Зөвлөл 15 гишүүнтэй байна.

27 дугаар зүйл.Орон нутгийн зэрэглэлтэй хотын Зөвлөлийн гишүүний тоо

27.1.Орон нутгийн зэрэглэлтэй хотын Зөвлөлийн гишүүний тоог доор дурдсанаар тогтооно:

27.1.1.оршин суугчийн тоо нь 50 000 хүртэл бол 25;

27.1.2.оршин суугчийн тоо нь 50 000-аас дээш бол 29.

28 дугаар зүйл.Тосгоны Зөвлөлийн гишүүний тоо

28.1.Тосгоны Зөвлөлийн гишүүний тоог доор дурдсанаар тогтооно:

28.1.1.оршин суугчийн тоо нь 5 000 хүртэл бол 15;

28.1.2.оршин суугчийн тоо нь 5 000-аас дээш бол 19.

29 дүгээр зүйл.Зөвлөлийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох

29.1.Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дараах тохиолдолд хугацаанаас өмнө дуусгавар болно:

29.1.1.Зөвлөлийн нийт гишүүдийн олонх нь тухайн Зөвлөл бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж санал оруулсныг нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргавал тухайн Зөвлөл өөрөө тарна;

29.1.2. ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 50 хоногийн дотор анхдугаар хуралдаан хуралдаж чадаагүй, эсхүл Зөвлөлийн хуралдааныг товлон зарлаж, хуралдахаар товлосон өдрөөс хойш хуралдахгүй 60-аас дээш хоног өнгөрсөн бол Зөвлөлийг Захирагч тараана;

29.1.3. Хуульд заасан хугацаанд төсвөө батлаагүй бол Захирагчийн санал оруулснаар улсын зэрэглэлтэй хотын хувьд Засгийн газар, орон нутгийн зэрэглэлтэй хот болон тосгоны хувьд түүний оршин байгаа аймгийн Засаг дарга тараана.

29.2. Зөвлөлийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд ээлжит бус сонгуулийг 30 хоногийн дотор энэ хуулийн 52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсэгт заасан журмын дагуу товлон зарлана.

30 дугаар зүйл. Зөвлөлийн гишүүн

30.1. Зөвлөлийн гишүүн нь хот, тосгоны өөрийн удирдлагын байгууллагад сонгогдсон, оршин суугчдын нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлэгч мөн.

30.2. Гишүүний бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

30.3. Гишүүний бүрэн эрхийн хугацаа түүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тогтоол батлагдсанаар эхэлж, шинээр сонгогдсон гишүүний бүрэн эрх эхэлснээр дуусгавар болно.

30.4. Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

30.5. Зөвлөлийн гишүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

30.5.1. тухайн хот, тосгоны байнгын оршин суугч байж сүүлийн гурван жил амьдарсан байх;

30.5.2. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх;

30.5.3. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх;

30.5.4. эрх зүйн бүрэн чадамжтай байх.

30.6. Гишүүн нь үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн дүрэмтэй байх бөгөөд ёс зүйн дүрмийг Зөвлөл батална.

31 дүгээр зүйл. Зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

31.1. Зөвлөлийн гишүүн нь дараах эрхтэй байна:

31.1.1. асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох;

31.1.2. Зөвлөлийн хороонд харьяалагдах;

31.1.3. хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж хариулт авах, санал гаргах, санал хураалгах;

31.1.4.энэ хуулийн 37.2-т заасны дагуу тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах;

31.1.5.Зөвлөлөөс сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонголыг хэлэлцэх санал гаргах;

31.1.6.Зөвлөлийн шийдвэрийг оршин суугчдад тайлбарлан таниулах;

31.1.7.Зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг хангах, оршин суугчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Захирагчид асуулт, асуулга тавих;

31.1.8.хууль тогтоомжид заасан бусад эрх.

31.2.Зөвлөлийн гишүүн нь дараах үүрэгтэй байна:

31.2.1.оршин суугчидтай тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу хариу өгөх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах;

31.2.2.гишүүн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохоос татгалзах;

31.2.3.Зөвлөлийн гишүүний хувьд хийсэн ажлынхаа талаарх мэдээллийг Зөвлөлийн цахим хуудсаар болон бусад хэлбэрээр оршин суугчдад мэдээлэх;

31.2.4.хууль, Зөвлөлийн гишүүний ёс зүйн дүрмийг баримтлах.

32 дугаар зүйл.Зөвлөлийн гишүүний үйл ажиллагаанд хориглох зүйл

32.1.Зөвлөлийн гишүүний үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

32.1.1.хот, тосгоны Захирагчийн харьяа болон үйл ажиллагаагаа хариуцан тайлагнадаг, түүнээс санхүүжилт авдаг аливаа байгууллага, бүтцийн нэгжид удирдах ажил, албан тушаал эрхлэх;

32.1.2.Зөвлөлийн гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулах, хувьдаа ашиглах;

32.1.3.бүрэн эрхийн хугацаандаа улс төрийн намын сонгуульт үүрэг хүлээх;

32.1.4.хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар Зөвлөлийн хуралд зориудаар оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарах.

33 дугаар зүйл.Зөвлөлийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох

33.1.Зөвлөлийн гишүүний бүрэн эрх дараах үндэслэлээр хугацаанаас өмнө дуусгавар болно:

33.1.1.нас барсан;

33.1.2.хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;

33.1.3.өвчний улмаас цаашид бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гарсан;

33.1.4.гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон;

33.1.5.тухайн хот, тосгоноос шилжсэн;

33.1.6.төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон;

33.1.7.энэ хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 33.1.3 дахь заалтыг зөрчсөн;

33.1.8.Зөвлөлийн гишүүний ёс зүйн дүрмийг удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн;

33.1.9.Зөвлөлийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох үндэслэл бүхий шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон.

33.2.Зөвлөлийн гишүүнийг энэ зүйлийн 33.1.2, 33.1.3, 33.1.5, 33.1.6-д заасан тохиолдолд чөлөөлөх, 33.1.4, 33.1.7, 33.1.8-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг Зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

33.3.Энэ зүйлийн 33.1.1, 33.1.9-д заасан нөхцөл үүссэн бол гишүүний бүрэн эрх дуусгавар болсонд тооцно.

34 дүгээр зүйл.Зөвлөлийн гишүүний үйл ажиллагааны баталгаа

34.1.Зөвлөлийн гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг тухайн Зөвлөл батална.

34.2.Зөвлөлийн төсөвт гишүүний үйл ажиллагааны болон тэдгээрийг чадавхжуулах зардлыг тусгана.

34.3.Зөвлөлийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь холбогдох байгууллага, албан тушаалтан дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

34.4.Зөвлөлийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь аливаа албан тушаалтан, улс төрийн нам, бусад байгууллага хөндлөнгөөс оролцох, үүрэг хүлээлгэхийг хориглоно.

35 дугаар зүйл.Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

35.1.Зөвлөл нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Зөвлөлийн тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий хороо байгуулан ажиллуулж болно.

35.2.Зөвлөлийн хороог түүний бүрэн эрхийн хугацаагаар байгуулах бөгөөд хорооны даргыг тухайн хорооны гишүүдийн дотроос сонгоно.

35.3.Хороо нь тухайн Зөвлөлд ажлаа хариуцан тайлагнана.

35.4.Зөвлөл нь тодорхой асуудлаар санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

35.5.Хороо, ажлын хэсэг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны чиглэл, бүрэлдэхүүн, ажиллах журмыг Зөвлөл тогтооно.

35.6.Зөвлөлийн бүтцэд энэ зүйлийн 35.5-д зааснаас гадна улс төрийн нам, эвслийн болон бусад нэгж байгуулахыг хориглоно.

36 дугаар зүйл.Зөвлөлийн хуралдаан

36.1.Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

36.2.Зөвлөлийн ээлжит хуралдааныг сард нэг удаа хийнэ.

36.3.Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар эсхүл Зөвлөлийн дарга, Захирагчийн санаачлагаар хуралдуулна.

36.4.Зөвлөлийн анхдугаар хуралдааныг ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 20 хоногийн дотор, бусад хуралдааныг тухайн Зөвлөлийн дарга хуралдаан эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө зарлан хуралдуулна.

36.5.Зөвлөлийн анхдугаар хуралдааныг шинээр сонгогдсон гишүүдийн насаар хамгийн ахмад нь, бусад хуралдааныг Зөвлөлийн дарга, түүний эзгүйд даргын санал болгосноор гишүүдийн аль нэг нь удирдана.

36.6.Зөвлөлийн хуралдаанд нийт гишүүдийн дийлэнх олонх нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцож, асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхоор шийдвэрлэнэ.

36.7.Хуралдааны дэгийг Зөвлөл өөрөө тогтоож тогтоолоор батална.

37 дугаар зүйл.Зөвлөлд асуудал оруулах

37.1.Хот, тосгоны Захирагч асуудал санаачлан Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй байна.

37.2.Зөвлөлийн үйл ажиллагааны дотоод зохион байгуулалтын асуудлаар хороо, гишүүн асуудал санаачлан Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй байна.

37.3.Энэ хуулийн 37.1-д заасан саналд холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж, хуралдаан болохоос ажлын гурваас доошгүй хоногийн өмнө Зөвлөлийн гишүүдэд тараах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй.

37.4.Улсын болон орон нутгийн шинжтэй асуудлаар гэнэтийн болон хойшлуулшгүй тохиолдолд Зөвлөлийн хуралдаан хуралдах тохиолдолд энэ

хуулийн 37.3-т заасан хугацааг баримтлаагүй нь хуралдааны шийдвэрийг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.

38 дугаар зүйл.Зөвлөлийн шийдвэр

38.1.Зөвлөл хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална.

38.2.Тогтоолд Зөвлөлийн дарга, Зөвлөлийн даргыг сонгох, чөлөөлөх тухай тогтоолд тухайн хуралдааныг даргалагч тус тус гарын үсэг зурна.

38.3.Зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар Зөвлөлийн дарга захирамж гаргах эрхтэй.

39 дүгээр зүйл.Зөвлөлийн шийдвэрт хориг тавих

39.1.Зөвлөл Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомж зөрчсөн, санхүүгийн эх үүсвэргүй шийдвэр гаргасан гэж үзвэл Захирагч тухайн шийдвэрт хориг тавина.

39.2.Хоригийг тухайн шийдвэр батлагдсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан бичгээр тавих бөгөөд хориг тавих болсон үндэслэлийг тодорхой заана.

39.3.Зөвлөл хоригийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх бөгөөд түүнийг гишүүдийн олонх нь хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн шийдвэр, тэдгээрийн холбогдох хэсгийн заалт хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

39.4.Зөвлөлийн шийдвэрт бүхэлд нь хориг тавьсан бол уг шийдвэрийн үйлчлэлийг бүрэн хэмжээгээр, хэсэгчлэн хориг тавьсан бол холбогдох зүйл, хэсэг, заалтын үйлчлэлийг хоригийг хэлэлцэн шийдвэрлэх хүртэлх хугацаанд түдгэлзсэнд тооцно.

39.5.Хот, тосгоны Захирагчийг огцруулах тухай Зөвлөлийн шийдвэрт Захирагч хориг тавих эрхгүй.

40 дүгээр зүйл.Зөвлөлийн даргын бүрэн эрх

40.1.Зөвлөлийн дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

40.1.1.Зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг хангах;

40.1.2.Зөвлөлийн хуралдааныг даргалах, гарсан шийдвэрийг ёсчилж баталгаажуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

40.1.3.Зөвлөлийн хороо, ажлын хэсэг, гишүүд бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлж, зохион байгуулалтын удирдлагаар хангах;

40.1.4.эрх бүхий этгээдээс Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр тавьсан саналыг хүлээн авах, гарах шийдвэрийн төслийг боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

40.1.5.Зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг хянан шалгах ажлыг зохион байгуулах;

40.1.6.Зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилуулах саналыг хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх;

40.1.7.Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

40.1.8.хот, тосгоны Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж биелэлтийг хангуулах арга хэмжээг Зөвлөлийн нэрийн өмнөөс авч ажиллах;

40.1.9.оршин суугч, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн Зөвлөлд ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах.

40.2.Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нь орон тооны байна.

41 дүгээр зүйл. Зөвлөлийн даргыг сонгох, огцруулах, чөлөөлөх

41.1.Ээлжит сонгуулийн дараах анхдугаар хуралдаанаар Зөвлөлийн даргыг дөрвөн жилийн хугацаагаар гишүүдийн дотроос сонгоно.

41.2.Зөвлөлийн гишүүд Зөвлөлийн даргад өөрийн болон бусад гишүүний нэрийг дэвшүүлэх эрхтэй.

41.3.Зөвлөлийн даргыг нууц санал хураалтаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно.

41.4.энэ хуулийн 41.3-т заасны дагуу нэр дэвшигчдийн аль нь ч олонхын санал аваагүй бол санал тэнцсэн буюу хамгийн олон санал авсан хоёр төлөөлөгчийг хоёр дахь санал хураалтад оруулах бөгөөд тэдгээрийн хэн нь ч олонхын санал аваагүй бол энэ зүйлд заасан журмаар Зөвлөлийн даргад дахин нэр дэвшүүлнэ.

41.5.Хурлын төлөөлөгчид санал хураалтад оролцохдоо зөвхөн нэг хүний төлөө санал өгөх бөгөөд нэр дэвшигч өөрөө санал хураалтад оролцох эрхтэй байна.

41.6.Гишүүд Зөвлөлийн даргын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хэлэлцээд хангалтгүй гэсэн үнэлгээ авсан өгсөн бол нийт гишүүдийн олонхийн саналаар огцруулна.

41.7.Даргыг энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан Зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх үндэслэл бүрдсэн бол түүнийг хугацаанаас өмнө чөлөөлж болно.

41.8.Зөвлөлийн даргыг хугацаанаас өмнө огцруулсан болон чөлөөлсөн бол шинээр сонгогдсон даргын бүрэн эрх өмнөх даргын бүрэн эрх үлдсэн хугацаанд үргэлжилнэ.

42 дугаар зүйл.Зөвлөлийн ажлын алба

42.1.Хот, тосгоны Зөвлөл ажлын албатай байна.

42.2.Улсын зэрэглэлтэй хотын Зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газар, орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны Зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас баталсан жишгийн дагуу тухайн хот, тосгоны Зөвлөл батална.

42.3.Хот, тосгоны Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ажлын албаны дарга байна.

43 дугаар зүйл.Зөвлөлийн төсөв, тэмдэг

43.1.Зөвлөл төсөвтэй байх бөгөөд төсвийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга захиран зарцуулна.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан төсөв нь Зөвлөлийн үйл ажиллагааны болон ажлын албаны төсвөөс бүрдэнэ.

43.3.Зөвлөл тогтоосон журмаар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ ХОТ, ТОСГОНЫ ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

44 дүгээр зүйл.Хот, тосгоны захирагч

44.1.Хот, тосгоныг өдөр тутамд удирдах, Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх гүйцэтгэх удирдлага нь оршин суугчдаас сонгосон хот, тосгоны Захирагч мөн.

44.2.Засгийн газар, төрийн бусад байгууллагын шийдвэрийг биелүүлэх ажлыг гэрээний үндсэн дээр Захирагч хэрэгжүүлнэ.

44.3.Захирагчийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

44.4.Захирагчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон бол шинээр сонгогдох Захирагчийн бүрэн эрхийн хугацаа нь өмнөх Захирагчийн бүрэн эрхийн үлдсэн хугацаатай тэнцүү байна.

44.5.Захирагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий орлогч, ажлын албатай байх бөгөөд ажлын албаны бүтэц, орон тоог Засгийн газар нэг бүрчлэн буюу Засгийн газраас тогтоосон жишигт нийцүүлэн Зөвлөл тогтооно.

45 дугаар зүйл.Захирагчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох

45.1.Захирагчийг дор дурдсан үндэслэлээр Зөвлөл хугацаанаас өмнө чөлөөлнө:

45.1.1.нас барсан;

45.1.2.хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;

45.1.3.өвчний улмаас цаашид бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гарсан;

45.1.4.тухайн хот, тосгоноос шилжсэн;

45.1.5.өөр ажил, албан тушаалд томилогдсон.

45.2.Захирагчийг доор дурдсан үндэслэлээр Зөвлөл огцруулна:

45.2.1.улсын зэрэглэлтэй хотын захирагч хууль, гэрээнд заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн гэсэн үндэслэлээр Ерөнхий сайд түүнийг огцруулах шаардлага тавьсныг Зөвлөлийн нийт гишүүний олонх хүлээн авсан;

45.2.2.орон нутгийн зэрэглэлтэй хотын захирагч хууль, гэрээнд заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзэж аймгийн Засаг дарга түүнийг огцруулах шаардлага тавьсныг Зөвлөлийн нийт гишүүний олонх хүлээн авсан;

45.2.3.тосгоны захирагч хууль, гэрээнд заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн гэсэн үндэслэлээр аймгийн Засаг дарга түүнийг огцруулах шаардлага тавьсныг Зөвлөлийн нийт гишүүний олонх хүлээн авсан;

45.2.4.гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон;

45.2.5.хууль тогтоомж удаа дараа эсхүл ноцтой зөрчсөн болох нь холбогдох байгууллага, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон.

45.3.Захирагчийг доор дурдсан үндэслэлээр Зөвлөлийн нийт гишүүний олонхын саналаар эгүүлэн татна:

45.3.1.улсын зэрэглэлтэй хотын Захирагчийг сонгуулийн эрх бүхий оршин суугчдын 30-аас доошгүй хувь нь үйл ажиллагаагаа хангалтгүй хэрэгжүүлсэн гэж үзэж огцруулах санал гаргасан;

45.3.2.орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчийг сонгуулийн эрх бүхий оршин суугчдын 40-өөс доошгүй хувь нь үйл ажиллагаагаа хангалтгүй хэрэгжүүлсэн гэж үзэж огцруулах санал гаргасан;

45.3.3.тосгоны Захирагчийг сонгуулийн эрх бүхий оршин суугчдын 50-аас доошгүй хувь нь үйл ажиллагаагаа хангалтгүй хэрэгжүүлсэн гэж үзэж огцруулах санал гаргасан;

45.4.Энэ зүйлийн 45.1, 45.2, 45.3-т заасан нөхцөл бүрдсэн бол хот, тосгоны Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг Зөвлөлийн дарга 7 хоногийн дотор зарлаж хуралдуулан асуудлыг шийдвэрлүүлнэ.

45.5.Захирагчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд ээлжит бус сонгуулийг 30 хоногийн дотор энэ хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т заасан журмын дагуу товлон зарлана.

46 дугаар зүйл.Захирагчид хариуцлага хүлээлгэх

46.1.Энэ хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т заасан үндэслэлгүй бол Захирагчид дараах сахилгын шийтгэл ногдуулна:

46.1.1.Зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг хангалтгүй биелүүлсэн нь гэж Зөвлөл дүгнэсэн;

46.1.2.хот, тосгоны Захирагчийн үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж Зөвлөл дүгнэсэн;

46.1.3.хууль, гэрээгээр хүлээсэн хууль биелүүлэх ажлыг хангалтгүй биелүүлсэн гэж Ерөнхий сайд, эсхүл аймгийн Засаг дарга үзэж хариуцлага хүлээлгэх асуудлыг тавьсан.

46.2.Зөвлөл энэ хуулийн 46.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр Захирагчид доор дурдсан шийтгэл ногдуулна:

46.2.1.сануулах;

46.2.2.үндсэн цалинг 20 хүртэлх хувиар 3 сар хүртэлх хугацаагаар хасах.

46.3.Энэхүү хуулийн 46.2-т заасан шийтгэлийг шат дараалан ногдуулна.

47 дугаар зүйл.Захирагч үйл ажиллагаагаа Зөвлөлд тайлагнах

47.1.Захирагч үйл ажиллагааныхаа тайланг жил бүр хот, тосгоны Зөвлөлд тайлагнана.

47.2.Захирагч хот, тосгоны Зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийн талаар тогтоосон хугацаанд Зөвлөлд мэдээлнэ.

48 дугаар зүйл.Захирагчийн шийдвэр

48.1.Захирагч энэ хууль, бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.

48.2.Захирагч эдэлбэр газрын хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон акт гаргаж Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу бүртгүүлнэ.

48.3.Улсын зэрэглэлтэй хотын Захирагч өөрийн болон түүнд шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх асуудлаар гаргасан захирамж хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө, эсхүл Ерөнхий сайд; орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч гаргасан захирамж хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө эсхүл оршин байгаа аймгийн Засаг дарга тус тус хүчингүй болгоно.

49 дүгээр зүйл.Хот, тосгоны захирагч үйл ажиллагаагаа мэдээлэх

49.1.Захирагч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тайланг хот, тосгоны оршин суугчдад жилд нэгээс доошгүй удаа биечлэн болон холбогдох бусад мэдээллийн хэрэгслээр хүргэнэ.

50 дугаар зүйл.Захирагчийн ажлын алба

50.1.Захирагчийн ажлын алба нь доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

50.1.1.Захирагчийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;

50.1.2.Зөвлөл, Захирагчийг шаардлагатай мэдээллээр хангах;

50.1.3.хууль тогтоомж, Засгийн газар, Зөвлөл, Захирагчийн шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;

50.1.4.Захирагчийн бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

50.1.5.хот, тосгоны удирдлагын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;

50.1.6.татварын алба хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээллийг гаргаж өгөх;

50.1.7. хуульд заасан бусад үйл ажиллагааг зохион байгуулах.

50.2.Захирагчийн ажлын албаны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

51 дүгээр зүйл.Хот, тосгоны захирагчийн бүрэн эрхийн баталгаа

51.1.Хот, тосгоны Захирагч бүрэн эрхээ хэрэгжүүлэх дараах баталгаагаар хангагдана:

51.1.1.хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан хот, тосгоны захирагчийн шийдвэрийг тухайн хот, тосгоны эдэлбэр газар дах аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугч биелүүлэх үүрэгтэй;

51.1.2. Захирагч Зөвлөлийн шийдвэр, хууль тогтоомжийг биелүүлэх зорилгоор эдэлбэр газар дах аж ахуйн нэгж, байгууллагатай нийтийн эрх зүйн гэрээ байгуулж болно;

51.1.3.хот, тосгоны захирагч нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудастай байна;

51.1.4.хот, тосгоны захирагчийн үйл ажиллагааны зардлыг тухайн хот, тосгонд хуваарилсан төсвөөс санхүүжүүлнэ.

ГУРАВДУГААР ДЭД БҮЛЭГ ХОТ, ТОСГОНЫ УДИРДЛАГЫН СОНГУУЛЬ

52 дугаар зүйл.Хот, тосгоны Зөвлөлийн сонгуулийн нийтлэг журам

52.1.Хот, тосгоны Зөвлөлийн сонгуулийг тухайн хот, тосгоны сонгуулийн эрх бүхий байнгын оршин суугчид нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

52.2.Улсын зэрэглэлтэй хотын хорооны Зөвлөлийн сонгуулийг энэ хуулийн 52.1-д заасан журмын дагуу тухайн хотын Зөвлөлийн сонгуультай хамтатган явуулна.

52.3.Хот, тосгоны Зөвлөлийн сонгуулийн журмыг Улсын Их Хурал тогтооно.

53 дугаар зүйл.Хот, тосгоны Зөвлөлийн гишүүнд нэр дэвших

53.1.Хотод 500-аас доошгүй, тосгонд 100-аас доошгүй сонгуулийн эрх бүхий оршин суугчийн дэмжлэг авсан иргэн хот, тосгоны Зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлнэ.

53.2.Хот, тосгоны сонгуулийн эрх бүхий оршин суугч энэ зүйлийн 53.1 дэх хэсэгт заасны дагуу хэдэн ч хүнийг дэмжиж болно.

53.3.Хот, тосгоны Зөвлөлийн гишүүнд улс төрийн нам нэр дэвшүүлж оролцохгүй.

54 дүгээр зүйл.Хот, тосгоны Захирагчийн сонгуулийн нийтлэг журам

54.1.Хот, тосгоны Захирагчийг тухайн хот, тосгоны сонгуулийн эрх бүхий байнгын оршин суугчид нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

54.2.Хот, тосгоны Захирагчийн сонгуулийн журмыг Улсын Их Хурал тогтооно.

55 дугаар зүйл.Хот, тосгоны Захирагчид нэр дэвших

55.1.Хотын Захирагчид нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:

55.1.1.магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй;

55.1.2.таваас доошгүй жил удирдах ажил хийсэн туршлагатай;

55.1.3.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх;

55.1.4.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх;

55.1.5.ялгүй байх.

55.2.Тосгоны Захирагчид нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:

55.2.1.дээд боловсролтой;

55.2.2.удирдах ажлын туршлагатай;

55.2.3.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх;

55.2.4. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх;

55.2.5. ялгүй байх.

55.3. Улсын зэрэглэлтэй хотын хувьд 1000-аас доошгүй, орон нутгийн зэрэглэлтэй хотын хувьд 500-аас доошгүй, тосгонд 100-аас доошгүй оршин суугчийн дэмжлэг авсан иргэн хот, тосгоны Захирагчид нэрээ дэвшүүлнэ.

55.4. Хот, тосгоны сонгуулийн эрх бүхий оршин суугч энэ зүйлийн 55.3 дахь хэсэгт заасны дагуу хэдэн ч хүнийг дэмжиж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ ХОТ, ТОСГОНЫ УДИРДЛАГЫН БҮРЭН ЭРХ

НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ ХОТ, ТОСГОНЫ ӨӨРИЙН УДИРДЛАГЫН БҮРЭН ЭРХ

56 дугаар зүйл. Хот, тосгоны Зөвлөлийн нийтлэг бүрэн эрх

56.1. Хот, тосгоны Зөвлөл дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

56.1.1. хот, тосгоны хөгжлийн дунд хугацааны бодлого болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах;

56.1.2. Зөвлөлийн даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах;

56.1.3. хуульд заасан үндэслэлээр Захирагчийг чөлөөлөх, огцруулах, эгүүлэн татах;

56.1.4. Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтоосны дагуу хот, тосгоны Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тоо, цалин, урамшууллыг батлах;

56.1.5. хот, тосгоны Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;

56.1.6. зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлж буй Захирагчийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

56.1.7. хот, тосгоны Захирагчийн өргөн мэдүүлснээр төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлах;

56.1.8. хот, тосгоны өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;

56.1.9. хот, тосгоны өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;

56.1.10. оршин суугчдын нийтлэг ашиг сонирхол, оролцоог хангах үүднээс санал асуулга зохион байгуулах шийдвэр гаргах;

56.1.11.захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх;

56.1.12.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

57 дугаар зүйл.Улсын зэрэглэлтэй хотын Зөвлөлийн бүрэн эрх

57.1.Улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл нь энэ хуулийн 56 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

57.1.1.хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;

57.1.2.Зөвлөлийн хороо, ажлын хэсэг байгуулах, хорооны дарга, бүрэлдэхүүнийг сонгох, өөрчлөх;

57.1.3.Захирагчийн өргөн мэдүүлснээр хуульд заасан үндэслэл журмын дагуу үнэт цаас гаргах, зээл авах зөвшөөрөл олгох;

57.1.4.улсын зэрэглэлтэй хотын тусгай чиг үүрэгт хамаарахаар энэ хуулиар тогтоосон асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

57.1.5.улсын зэрэглэлтэй хотод шилжүүлсэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зарим бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

57.1.6.хотын хороог байгуулж, хилийн заагийг батлах;

57.1.7.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

58 дугаар зүйл.Улсын зэрэглэлтэй хотын хорооны Зөвлөлийн бүрэн эрх

58.1.Улсын зэрэглэлтэй хотын хорооны Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

58.1.1.хорооны жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хотын Зөвлөлөөс тогтоосон хүрээнд нийцүүлэн батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах;

58.1.2.Хорооны Зөвлөлийн даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах;

58.1.3.хуульд заасан үндэслэлээр хорооны Захирагчийг чөлөөлөх, огцруулах санал гаргах;

58.1.4.хорооны Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тоо, цалин, урамшуулал, зардлыг батлах;

58.1.5.хорооны Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;

58.1.6.хорооны зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлж буй Захирагчийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

58.1.7.хорооны Захирагчийн өргөн мэдүүлснээр төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлах;

58.1.8.хорооны өмчийн хувьд өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;

58.1.9.оршин суугчдын нийтлэг ашиг сонирхол, оролцоог хангах үүднээс санал асуулга зохион байгуулах шийдвэр гаргах;

58.1.10.Зөвлөлийн хороо байгуулах, хорооны дарга, бүрэлдэхүүнийг сонгох, өөрчлөх;

58.1.11.хорооны Зөвлөлд шилжүүлсэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зарим бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

58.1.12.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

59 дүгээр зүйл.Орон нутгийн зэрэглэлтэй хотын Зөвлөлийн бүрэн эрх

59.1.Орон нутгийн зэрэглэлтэй хотын Зөвлөл нь энэ хуулийн 56 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

59.1.1.хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;

59.1.2.Зөвлөлийн хороо, түр хороо байгуулах, түр хороог татан буулгах, хорооны дарга, бүрэлдэхүүнийг сонгох, өөрчлөх

59.1.3.орон нутгийн зэрэглэлтэй хотод шилжүүлсэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зарим бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

59.1.4.орон нутгийн зэрэглэлтэй хотод шилжүүлсэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зарим бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

59.1.5.хуульд тогтоомжид заасны дагуу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

59.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

60 дугаар зүйл.Тосгоны Зөвлөлийн бүрэн эрх

60.1.Тосгоны Зөвлөл нь энэ хуулийн 56 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

60.1.1.энэ хуулиар тогтоосон тухайн тосгоны чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

60.1.2.хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх;

60.1.3.тосгонд шилжүүлсэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зарим бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

60.1.4.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ ХОТ, ТОСГОНЫ ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БҮРЭН ЭРХ

61 дүгээр зүйл. Хот, тосгоны захирагчийн нийтлэг бүрэн эрх

61.1. Хот, тосгоны Захирагч нь дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

61.1.1. нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл, хөтөлбөрийг боловсруулан Зөвлөлөөр батлуулж, гүйцэтгэлийг зохион байгуулах;

61.1.2. хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөг хууль тогтоомжид заасан журмаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

61.1.3. төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлж, төсвийг захиран зарцуулах;

61.1.4. хот, тосгоны нийгэм, эдийн засгийн хөгжилд шаардлагатай санхүү, эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, нөөцийн болон газар ашиглалтын зэрэг мэдээ, тайланг тухайн хот, тосгоны холбогдох байгууллага, албан тушаалтнаар гаргуулах;

61.1.5. хот, тосгоны өмчийг хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулж, тэдгээрийг шинээр бий болгох, түрээслэх асуудлыг шийдвэрлэх;

61.1.6. хот, тосгоны оршин суугчдын ашиг сонирхолд нийцүүлэн хот, тосгоны өмчийг хувьчлах асуудлыг боловсруулж хууль тогтоомжид заасан журмаар шийдвэрлүүлэх;

61.1.6. оршин суугчдын хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоход тусламж дэмжлэг үзүүлэх;

61.1.7. хот, тосгоны өмчит болон өмч давамгайлсан хуулийн этгээдийн үйл ажиллагааг чиглүүлж, удирдлагыг нь томилж, чөлөөлөх;

61.1.8. хот, тосгоны нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж, хүнсний болон өргөн хэрэгцээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх талаар гэрээ байгуулах;

61.1.9. эдэлбэр газрын ашиглалтыг төлөвлөх, төлөвлөгөөг батлуулах;

61.1.10. хот, тосгоны эдэлбэр газарт явуулж буй газар зохион байгуулалтын төлөвлөгөөний талаар санал гаргах;

61.1.11. хот, тосгоны усны нөөцийг тогтоосон журмын дагуу ашиглуулах;

61.1.12. хот, тосгоны ариун цэвэр, эрүүл ахуй-халдваргүйжүүлэлтийн арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;

61.1.13.хот, тосгоны экологийн байдлын талаар оршин суугчдад мэдээлэл хийх;

61.1.14.хот, тосгоны хүрээлэн байгаа орчин, ногоон бүсийг хамгаалах, сэргээх арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

61.1.15.хот, тосгоны эрүүл ахуй, хэм хэмжээ зөрчсөн барилга байгууламжийг барьж ашиглахыг зогсоох асуудлыг эрх бүхий байгууллагад санал оруулан шийдвэрлүүлэх;

61.1.16.хот, тосгоны дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

61.1.17.хот, тосгоны тохижилтын ажилд аж ахуйн нэгж, байгууллагыг гэрээний үндсэн дээр, түүнчлэн оршин суугчдыг зохион байгуулж оролцуулах;

61.1.18.хот, тосгоны худалдаа, үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарийг тогтоох;

61.1.19.худалдаа, үйлчилгээний газарт эрүүл ахуйн шаардлагыг хангуулах;

61.1.20.худалдаа, үзэсгэлэн болон үйлчилгээний бусад арга хэмжээг зохион байгуулах.

61.1.21.оршин суугчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулж батлуулан хэрэгжүүлэх;

61.1.22.боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгэм хамгаалал, халамж, биеийн тамир, спортын үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг үзүүлж, удирдан зохион байгуулах, хяналт тавих;

61.1.23.оршин суугчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн амьдрах орчин, үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх;

61.1.24.Зөвлөлөөс баталсан хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний дагуу нарийвчилсан төлөвлөгөө, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

61.1.25.эдийн засаг, нийгмийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэрлэлийн дэд бүтцийн объектыг барих, засварлахад захиалагчийн үүрэг гүйцэтгэх;

61.1.26.хот, тосгоны эдэлбэр газарт барилга байгууламж барих зөвшөөрөл олгох талаар санал гарган, ашиглалтад орж байгаа орон сууц, иргэний зориулалттай барилга байгууламжийг хүлээн авах, хяналт тавих;

61.1.27.нийгмийн дэг журмыг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх талаар хууль хяналтын байгууллагатай харилцан ажиллаж, тэдгээрт туслалцаа үзүүлэх;

61.1.28.оршин суугчдын санал, өргөдөл, гомдол, тэдний ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон асуудлыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хянан шийдвэрлэх;

61.1.29.хот, тосгоны оршин суугчдын нийтлэг ашиг сонирхол, өмчийн талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

61.1.30.хот, тосгоны шагналыг бий болгох санал гаргах;

61.1.31.хот, тосгоны бэлгэдлийг Зөвлөлөөр батлуулах;

61.1.32.бусад улсын хот, тосгонтой холбоо тогтоож харилцах;

61.1.33.захирагчийн ажлын албаны ажилтныг томилж, чөлөөлөх;

61.1.33.хууль тогтоомж, гэрээнд заасан бусад бүрэн эрх.

62 дугаар зүйл.Улсын зэрэглэлтэй хотын захирагчийн бүрэн эрх

62.1.Улсын зэрэглэлтэй хотын Захирагч нь энэ хуулийн 60 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

62.1.1.улсын зэрэглэлтэй хотын хорооны Захирагчийг томилж, чөлөөлөх;

62.1.2.хотын өмчит болон өмч давамгайлсан хуулийн этгээдийн удирдлагыг томилж, чөлөөлөх;

62.1.3.хотын чанартай музей, театр, соёлын төвийн эрхлэгчийг томилж, чөлөөлөх;

62.1.4.хотын харьяалалтай биеийн тамир, спортын цогцолборын удирдлагыг томилж, чөлөөлөх;

62.1.5.олон нийтийн амралт, цэцэрлэгт хүрээлэнгийн удирдлагыг томилж, чөлөөлөх;

62.1.6.сургуулийн өмнөх, бага, дунд болон мэргэжлийн сургалтын байгууллагын удирдлагыг томилж, чөлөөлөх;

62.1.7.эмнэлгийн тусламж үйлчилгээний даргыг удирдлагыг томилж, чөлөөлөх;

62.1.8.Зөвлөлөөс баталсан хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу нарийвчилсан төлөвлөгөө, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

62.1.9.хотын эдэлбэр газар дахь газрыг хуульд тогтоомжид нийцүүлэн өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргах;

62.1.10.хотын эдэлбэр газар дахь ургамал, ан амьтан, ус, рашаан, байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулах;

62.1.11.түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалж, тэдгээрийн ашиглалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

62.1.12.нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл цагийн хуваарийг батлан, түүнчлэн оршин суугчдад үйлчилж байгаа тээврийн бусад байгууллагын үйл

ажиллагаанд болон төмөр зам, нисэх буудалд зорчигчдын үйлчилгээг зохион байгуулж байгаад хяналт тавих;

62.1.13.хотын худалдаа, ахуйн болон орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээг зохион байгуулах;

62.1.14.хот суурины замын хөдөлгөөний зохицуулалт, авто зогсоолын байршил тогтоох, арчлалтыг зохион байгуулах;

62.1.15.оршин суугчдаас нийгмийн хамгаалалт, дэмжлэг үзүүлбэл зохих амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур амьдралтай хэсэгт санхүүгийн болон эд материалын тусламж үзүүлэх санг зарим ажил, үйлчилгээнээс орсон орлогоос бүрдүүлж зохион байгуулах;

62.1.16.улсын зэрэглэлтэй хотын Захирагчаар шийдвэрлүүлэхээр гэрээгээр тусгайлан шилжүүлсэн асуудлыг шийдвэрлэх;

62.1.17.улсын зэрэглэлтэй хотын Захирагчид шилжүүлсэн Засаг даргын зарим бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

62.1.18.хууль тогтоомж, гэрээнд заасан бусад бүрэн эрх.

63 дугаар зүйл.Улсын зэрэглэлтэй хотын хорооны захирагчийн бүрэн эрх

63.1.Улсын зэрэглэлтэй хотын хорооны Захирагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

63.1.1.хорооны төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд хууль тогтоомжийн дагуу төсвийг захиран зарцуулах;

63.1.2.хорооны нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл, хөтөлбөрийг боловсруулан Зөвлөлөөр батлуулж, гүйцэтгэлийг зохион байгуулах;

63.1.3.хорооны өмчийг хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулж, тэдгээрийг шинээр бий болгох, түрээслэх асуудлыг шийдвэрлэх;

63.1.4.хорооны захирагчийн ажлын албаны ажилтныг томилж, чөлөөлөх;

63.1.5.хорооны өмчийг хувьчлах асуудлыг боловсруулж хууль тогтоомжид заасан журмаар шийдвэрлүүлэх;

63.1.6.хорооны усны нөөцийг тогтоосон журмын дагуу ашиглуулах;

63.1.7.хорооны тохижилтын ажилд аж ахуйн нэгж, байгууллагыг гэрээний үндсэн дээр, түүнчлэн оршин суугчдыг зохион байгуулж оролцуулах;

63.1.8.оршин суугчдын санал, өргөдөл, гомдол, тэдний ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон асуудлыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хянан шийдвэрлэх;

63.1.9.хотын Захирагчаас шилжүүлсэн бүрэн эрхийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх;

63.1.10.хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөг хууль тогтоомжид заасан журмаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

63.1.11.ариун цэвэр, эрүүл ахуй-халдваргүйжүүлэлтийн арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;

63.1.12.хорооны хүрээлэн байгаа орчин, ногоон бүсийг хамгаалах, сэргээх арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

63.1.13.хороонд хотын дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

63.1.14.хороонд худалдаа, үзэсгэлэн болон үйлчилгээний бусад арга хэмжээг зохион байгуулах;

63.1.15.хороонд явуулж буй газар зохион байгуулалтын төлөвлөгөөний талаар санал гаргах;

63.1.16.хороонд баригдаж буй барилга, байгууламжийн эрүүл ахуй, хөдөлмөр аюулгүй байдал, байгаль орчинд нөлөөлөх байдлыг талаар эрх бүхий байгууллагад санал оруулан шийдвэрлүүлэх;

63.1.17.хорооны худалдаа, үйлчилгээний газарт эрүүл ахуйн шаардлагыг хангуулах;

63.1.18.боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгэм хамгаалал, халамж, биеийн тамир, спортын үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг үзүүлж, удирдан зохион байгуулах, хяналт тавих;

63.1.19.оршин суугчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн амьдрах орчин, үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх;

63.1.20.нийгмийн дэг журмыг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх талаар хууль хяналтын байгууллагатай харилцан ажиллаж, тэдгээрт туслалцаа үзүүлэх;

63.1.21.оршин суугчдын хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоход тусламж дэмжлэг үзүүлэх;

63.1.22.хууль тогтоомж, гэрээнд заасан бусад бүрэн эрх.

64 дүгээр зүйл.Орон нутгийн зэрэглэлтэй хотын захирагчийн бүрэн эрх

64.1.Орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч нь энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

64.1.1.орон нутгийн зэрэглэлтэй хотын хорооны Захирагчийг томилж, чөлөөлөх;

64.1.2.хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцах;

64.1.3.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах чиглэлээр холбогдох хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

64.1.4.хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах;

64.1.5.байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх;

64.1.6.нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглах, бэлчээр, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, үржил шимийг нь дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах бусад арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулж Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

64.1.7.Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн тусгай хэрэгцээний газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах тухай шийдвэр гаргах;

64.1.8.Аймгийн Засаг даргын олгосон газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн талаарх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хооронд үүссэн маргааныг Газрын тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх;

64.1.9.хуульд заасан зориулалтаар эдэлбэр газар олгох;

64.1.10.эдэлбэр газрын байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн талаар гаргасан хотын Зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

64.1.11.эдэлбэр газарт нь газар ашиглах, эзэмших, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах;

64.1.12.оршин суугчдаас нийгмийн хамгаалалт, дэмжлэг үзүүлбэл зохих амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур амьдралтай хэсэгт санхүүгийн болон эд материалын тусламж үзүүлэх санг зарим ажил, үйлчилгээнээс орсон орлогоос бүрдүүлж зохион байгуулах;

64.1.13.түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалж, тэдгээрийн ашиглалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.

64.1.14.нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл цагийн хуваарийг батлан, түүнчлэн оршин суугчдад үйлчилж байгаа тээврийн бусад байгууллагын үйл ажиллагаанд болон төмөр зам, нисэх буудалд зорчигчдын үйлчилгээг зохион байгуулж байгаад хяналт тавих;

64.1.15.орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчаар шийдвэрлүүлэхээр гэрээгээр тусгайлан шилжүүлсэн асуудлыг шийдвэрлэх;

64.1.16.орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчид шилжүүлсэн Засаг даргын зарим бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

64.1.17.хууль тогтоомж, гэрээнд заасан бусад бүрэн эрх.

65 дугаар зүйл.Орон нутгийн зэрэглэлтэй хотын Хорооны захирагчийн бүрэн эрх

65.1.Орон нутгийн зэрэглэлтэй хотын хорооны Захирагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

65.1.1.хорооны Захирагчийн дэргэдэх зөвлөлийг тэргүүлэх, гишүүнийг томилж, чөлөөлөх;

65.1.2.хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах хотын Захирагчийн шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцах;

65.1.3.сургуулийн өмнөх насны хүүхдийг бүртгэж тухайн жилд нь сургуульд оруулах, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулах арга хэмжээ авах;

65.1.4.шаардлагатай иргэдийг асрамжийн болон халамжийн үйлчилгээнд хамруулах саналыг хууль тогтоомжийн дагуу хотын Захирагчид тавьж шийдвэрлүүлэх;

65.1.5.нутаг дэвсгэрийн хүн амын амьжиргааны түвшинг судалж, хууль тогтоомжид заасан хүрээнд нийгмийн халамж, үйлчилгээ зохион байгуулах;

65.1.6.гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед айл өрх, хүн, малыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийг зохих үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулах, хуульд заасан тохиолдолд хүн хүч, тээвэр, холбооны хэрэгсэл, эд хөрөнгийг дайчлах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;

65.1.7.хүн ам, өрхийн болон иргэний түр оршин суух бүртгэлийг зохих журмын дагуу бүртгэх;

65.1.8.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих;

65.1.9.гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

65.1.10.иргэнийг шагнаж урамшуулах, гачигдалтай иргэнд тусламж дэмжлэг үзүүлэх тухай саналыг хотын Захирагчид тавьж шийдвэрлүүлэх;

65.1.11.хууль тогтоомжоор багийн Засаг дарга хэрэгжүүлэхээр заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

65.1.12.хууль тогтоомж, гэрээнд заасан бусад бүрэн эрх.

66 дугаар зүйл.Тосгоны захирагчийн бүрэн эрх

66.1.Тосгоны Захирагч нь энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

66.1.1.тосгоны хэсгийн ахлагчийг томилж, чөлөөлөх;

66.1.2.хууль тогтоомж, Засгийн газар, аймгийн Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцах;

66.1.3.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах чиглэлээр холбогдох хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

66.1.4.байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх;

66.1.5.оршин суугчдаас нийгмийн хамгаалалт, дэмжлэг үзүүлбэл зохих амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур амьдралтай хэсэгт санхүүгийн болон эд материалын тусламж үзүүлэх санг зарим ажил, үйлчилгээнээс орсон орлогоос бүрдүүлж зохион байгуулах;

66.1.6.тосгоны Захирагчаар шийдвэрлүүлэхээр, гэрээгээр тусгайлан шилжүүлсэн асуудлыг шийдвэрлэх;

66.1.7.тосгоны Захирагчид шилжүүлсэн Засаг даргын зарим бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

66.1.8.тосгоныг төлөөлөн хуульд заасан болон өөрийн санаачилсан асуудлаар оршин суугчдын нийтлэг санал, хүсэлтийг авах ажлыг зохион байгуулах;

66.1.9.тосгоны төлөөлөн зохих шатны байгууллага, албан тушаалтанд шууд харилцах;

66.1.10.хууль тогтоомж, гэрээнд заасан бусад бүрэн эрх.

67 дугаар зүйл.Тосгоны хэсгийн Ахлагчийн бүрэн эрх

67.1.Тосгоны хэсгийн Ахлагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

67.1.1.хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах тосгоны Захирагчийн шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцах;

67.1.2.сургуулийн өмнөх насны хүүхдийг бүртгэж тухайн жилд нь сургуульд оруулах, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулах арга хэмжээ авах;

67.1.3.шаардлагатай иргэдийг асрамжийн болон халамжийн үйлчилгээнд хамруулах саналыг хууль тогтоомжийн дагуу тосгоны Захирагчид тавьж шийдвэрлүүлэх;

67.1.4.тосгоны оршин суугчдын амьжиргааны түвшинг судалж, хууль тогтоомжид заасан хүрээнд нийгмийн халамж, үйлчилгээ зохион байгуулах;

67.1.5.гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед айл өрх, хүн, малыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийг зохих үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулах, хуульд заасан тохиолдолд хүн хүч, тээвэр, холбооны хэрэгсэл, эд хөрөнгийг дайчлах ажлыг зохион байгуулах;

67.1.6.хүн ам, өрхийн болон иргэний түр оршин суух бүртгэлийг зохих журмын дагуу бүртгэх;

67.1.7.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих;

67.1.8.гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

67.1.9.иргэнийг шагнаж урамшуулах, гачигдалтай иргэнд тусламж дэмжлэг үзүүлэх тухай саналыг тосгоны Захирагчид тавьж шийдвэрлүүлэх;

67.1.10.хууль тогтоомж, гэрээнд зааснаар тосгоны хэсгийн Ахлагч хэрэгжүүлэхээр шилжүүлсэн асуудлыг хэрэгжүүлэх;

67.1.11.тосгоны Захирагчаас шилжүүлсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

67.1.12.хууль тогтоомж, гэрээнд заасан бусад бүрэн эрх.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХОТ, ТОСГОНЫ УДИРДЛАГА БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ

68 дугаар зүйл.Улсын зэрэглэлтэй хот Засгийн газартай харилцах

68.1.Улсын зэрэглэлтэй хот нь Засгийн газартай доор дурдсан асуудлаар харилцана:

68.1.1.энэ хууль, бусад хууль тогтоомжоор өөрт нь ногдуулсан хот, тосгоны эрхлэх асуудлыг шийдвэрлэхдээ төрийн бодлого Засгийн газрын шийдвэртэй уялдуулна;

68.1.2.төрөөс шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлсэн талаар Засгийн газар, холбогдох яам, агентлагийг мэдээллээр тогтмол хангана;

68.1.3.эдийн засаг, нийгмийн хөгжлийн тодорхой асуудлыг шийдвэрлүүлэхээр Засгийн газарт асуудал оруулна;

68.1.4.хууль, гэрээнд заасны дагуу шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлсэн ажлынхаа үр дүнг Ерөнхий сайдад тайлагнана.

68.1.5.хотын хөрөнгөөр шийдвэрлэх боломжгүй нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд саналаа шууд гаргана.

68.1.6.хотынхоо эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх талаар санал боловсруулж тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх;

68.1.7.хууль тогтоомжид заасан бусад асуудал.

68.2.Улсын зэрэглэлтэй хотын Захирагч төрөөс шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, тэдгээрт шаардагдах төсвийн санхүүжилтийг олгох асуудлаар холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нартай жил бүр гэрээ байгуулна.

68.3.Энэ хуулийн 68.2-т заасан гэрээний үр дүнг жил бүр дүгнэнэ.

68.4.Хотын удирдлагад тавих Засгийн газар, яам, агентлагийн хяналт нь төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр Зөвлөлд шилжүүлсэн чиг үүргийн зорилго, хэрэгжилтийг хангахад чиглэгдэнэ.

68.5.Яам, агентлаг болон хотын хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Засгийн газар шийдвэрлэнэ.

69 дүгээр зүйл.Орон нутгийн зэрэглэлтэй хот яам, агентлагтай харилцах

69.1.Орон нутгийн зэрэглэлтэй хот нь төрөөс аймагт шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх асуудлаар тухайн аймгийн удирдлагаар дамжуулан холбогдох яам, агентлагтай харилцана.

69.2.Хотын өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх асуудлаар хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол холбогдох яам, агентлагтай шууд харилцана.

69.3.Хотын удирдлагад тавих Засгийн газар, яам, агентлагийн хяналт нь төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр Зөвлөлд шилжүүлсэн чиг үүргийн зорилго, хэрэгжилтийг хангахад чиглэгдэнэ.

70 дугаар зүйл.Тосгон яам, агентлагтай харилцах

70.1.Тосгон нь төрөөс аймагт шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх асуудлаар тухайн аймгийн удирдлагаар дамжуулан холбогдох яам, агентлагтай харилцана.

71 дүгээр зүйл.Орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгоны Захирагч төрөөс шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх гэрээ байгуулах

71.1.Орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгоны Захирагч төрөөс шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, тэдгээрт шаардагдах төсвийн санхүүжилтийг олгох асуудлаар аймгийн Засаг даргатай жил бүр гэрээ байгуулна.

71.2.Энэ хуулийн 71.1-д заасан гэрээний үр дүнг жил бүр дүгнэнэ.

72 дугаар зүйл.Хот, тосгон, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын хамтын ажиллагаа

72.1.Хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор хот, тосгон, аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо хоорондоо нийтийн эрх зүйн гэрээ байгуулж болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ ХОТ, ТОСГОНЫ ОРШИН СУУГЧ, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

73 дугаар зүйл. Хот, тосгоны оршин суугч

73.1.Энэ хуульд заасан хот, тосгонд байнгын хаягаар бүртгүүлэн 183 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хот, тосгоны байнгын оршин суугч гэнэ.

73.2.Хот, тосгонд 183 хүртэлх хоногийн хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг түр оршин суугч гэнэ.

74 дүгээр зүйл. Хот, тосгоны оршин суугч хот, тосгоны удирдлагад оролцох

74.1.Иргэн хот, тосгоны оршин суугчийн хувьд хот, тосгоны амьдралын асуудлыг шийдвэрлэхэд шууд болон хот, тосгоны өөрийн удирдлагын байгууллагаар уламжлан оролцоно.

75 дугаар зүйл. Хот, тосгоны оршин суугч шийдвэр гаргах үйл ажиллагаанд шууд оролцох

75.1.Хот, тосгоны өөрийн удирдлагад дараах хэлбэрээр шууд оролцоно:

75.1.1.хот, тосгоны эдийн засаг, нийгмийн тодорхой асуудлыг хот, тосгоны Зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр санал гаргах;

75.1.2.хот, тосгоны амьдралын тодорхой асуудлаар хуульд зааснаар явуулах зөвлөлдөх санал асуулгад оролцох;

75.1.3.хот, тосгоны эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар нэг удаагийн эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах. Энэхүү санаачлагыг хот, тосгоны сонгуулийн эрх бүхий оршин суугчдын 10-аас доошгүй хувь нь дэмжиж, гарын үсэг зурсан тохиолдолд Зөвлөл хэлэлцэх үүрэгтэй.

75.2.Хот, тосгоны амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар санал асуулга явуулахыг сонгуулийн эрх бүхий оршин суугчид дараах хувиар дэмжиж гарын үсэг зурж хүсэлт гаргана.

75.2.1.30 000 хүртэл оршин суугчтай бол 20 хувь;

75.2.2.30 001-60 000 хүртэл оршин суугчтай бол 15 хувь;

75.2.3.60 001-100 000 хүртэл оршин суугчтай бол 12 хувь;

75.2.4.100 001-ээс дээш оршин суугчтай бол 10 хувь.

75.3.Энэ хуулийн 75.2-т заасны дагуу оршин суугчид хүсэлт гаргасан бол хот, тосгоны Зөвлөл санал асуулгыг заавал зохион байгуулах үүрэгтэй бөгөөд Захирагч тухайн санал асуулгын зохион байгуулалтыг хариуцаж ажиллана.

75.4.Энэ хуулийн 75.2-т заасан тодорхой асуудлыг шийдвэрлэх санал асуулгыг зохион байгуулах, эрхлэх явуулах, дүнг гаргах журмыг Улсын Их Хурал тогтооно.

76 дугаар зүйл. Хот, тосгоны оршин суугчийн эрх

76.1. Хот, тосгоны оршин суугч дараах эрхтэй:

76.1.1. сонгуулийн эрх бүхий оршин суугч нь тухайн хот, тосгоны удирдлагыг сонгох, түүнд сонгогдох;

76.1.2. хууль тогтоомжид заасан журмын дагуу хот, тосгоны удирдлагаас мэдээлэл авах, санал өгөх;

76.1.3. хот, тосгоны төсвийг боловсруулж, батлахад санал өгөх

76.1.4. хууль тогтоомжид заасан бусад эрх.

77 дугаар зүйл. Хот, тосгоны оршин суугчийн үүрэг

77.1. Хот, тосгоны оршин суугч дараахь үүрэг хүлээнэ:

77.1.1. хот, тосгоны эдэлбэр газрын хүрээнд хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

77.1.2. хот, тосгоны Зөвлөл болон Захирагчийн шийдвэр, хот, тосгоны дүрэм, стандартыг сахин биелүүлэх;

77.1.3. хотын татвар төлөх;

77.1.4. хотын соёл, харилцааны хэм хэмжээг хүндэтгэн сахих;

77.1.5. өөрийн өмчлөл, эзэмшлийн газрыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлж ашиглах;

77.1.6. хот, тосгоны хэмжээнд зохиогдож буй тохижилт, үйлчилгээ, цэвэрлэгээнд оролцох;

77.1.7. хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу суурьшлын бүсэд оршин сууж, орчноо цэвэр үзэмжтэй байлгах.

77.2. Хот, тосгонд түр оршин суугч нь амьдарч байх хугацаандаа энэ хуулийн 77.1-д заасан үүргийг хүлээнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

78 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

78.1. Хот, тосгоны удирдлагаас бусад байгууллага, албан тушаалтан, иргэдтэй холбогдон үүссэн дараахь маргааныг доор дурдсанаар шийдвэрлэнэ:

78.1.1.энэ хуулийн 68 дугаар зүйлийн 68.2-т заасан улсын зэрэглэлтэй хотын захирагч болон холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Ерөнхий сайд;

78.1.2.орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгоны удирдлагаас аймагт шилжүүлсэн төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээнээс үүдэлтэй маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол засаг, захиргааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага;

78.1.3.энэ хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-д заасан хот, тосгон болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хооронд байгуулсан гэрээнээс үүдэлтэй маргааныг гэрээнд өөрөөр заагаагүй бол шүүх;

78.1.3.улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгон хооронд байгуулсан гэрээнээс үүдэлтэй маргааныг шүүх тус тус шийдвэрлэнэ.

79 дүгээр зүйл. Бэлгэ тэмдэг

79.1.Хот, тосгоны бэлгэ тэмдэг нь туг, сүлд тэмдэг мөн.

79.2.Хот, тосгоны туг, сүлд тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журмыг хот, тосгоны Зөвлөл батална.

80 дугаар зүйл. Хотын бэлгэдэл, нэрэмжит цол, бусад шагнал

80.1.Хот нь өөрийн түүх, уламжлал, байгалийн онцлог зэргийг илэрхийлсэн бэлгэдэлтэй байж болох бөгөөд бэлгэдлийн хэв загварыг тухайн хотын оршин суугчдын саналыг харгалзан хотын захирагч батална.

80.2.Хотын хүндэт иргэний болзол хангасан болон хотыг хөгжүүлэх ажилд онцгой хувь нэмэр оруулсан хүмүүст хүндэт иргэн цол олгох, байгууллага, хамт олон, хүмүүсийг хүндэт тэмдэг, нэрэмжит болон бусад шагналаар шагнах, хүндэт дэвтэрт бичиж алдаршуулах асуудлыг Захирагч шийдвэрлэнэ.

81 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

81.1.Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг